БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/83/СТА-ТШЗ


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Утас: 99007576

Аудитын менежер: Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Б.Цэрэнчимэд
Утас: 88302569 Цахим хаяг: tserenchimedb@sudit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn

2018 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

## АГУУЛГА


1 Аудитын гэрчилгээ ....... 3

2 Аудитын тайлан ....... 5

2.1 Оршил ....... 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....... 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ....... 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ....... 6

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ....... 7

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....... 8

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ....... 8

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ....... 9

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ....... 9

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ....... 9

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ....... 9

2.11 Шилэн дансны мэдээлэл ....... 9

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ....... 10

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ....... 10

3 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН. ....... 11

3.1 Санхүүгийн байдлын тайлан ....... 11

3.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан ....... 12

3.3 Мөнгөн гүйлгээний тайлан ....... 13

3.4 Цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан ....... 15

3.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан ....... 16

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГА Ж.БАТТӨР ТАНАА

2019.02.01 № 2/08

танай ____________-ны №________________ т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын

D:\STA-2018\ХХААГазар\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2518479

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\STA-2018\ХХААГазар\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

# 2 Аудитын тайлан

## 2.1 Оршил

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ХХААГазрын дарга Ж. Баттөрд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаа
гүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.16-наас 2019.01.31–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.31-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.15-ны өдрийн 23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Цаг агаарын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлж, Мал эрүүлжүүлэх, малын халдварт болон халдваргүй өвчнөөс сэргийлэх дэвшилтэт арга технологийг боловсронгуй болгох, хүн амыг эрүүл хүнсээр хангах

юм” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Монгол Улсын Засгийн газрын 2016.12.21-ний өдрийн 193 тоот тогтоол, Сангийн сайдын 2018.08.07-ний өдрийн 207 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу төсвийн байгууллагад бүртгэлтэй барилга байгууламжийг дахин үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгах ажил тайлант онд хийгдсэн байна.

## 2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй

байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох" програм хангамж ашигладаг байна. /Программын нэрийг зөв бичих

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлын 1,0 хувиар сонгов.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардал нь 1767029,4 мянган төгрөг бөгөөд түүний 1,0 хувь болох 17670,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд санхүүгийн тайланд алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй бөгөөд энэ мэдээллийг B30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

## 2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй

## 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 327170,9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 327116,2 мянган төгрөг бөгөөд Батлагдсан төсвийг 54,7 мянган төгрөг хэмнэлттэй зарцуулсан байна. Үүнд албан томилолтын зардлыг 33,7 мянган, тогтмол зардлыг 5,3 мянган төгрөг, бусад урсгал зардлыг 15,7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

## 2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны аудитаар зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөөөгүй байна

## 2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН.

## 3.1 Санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **338,716,581.61** | **717,664,682.20** |
| **33** | **АВЛАГА** | 5,786,794.51 | 16,061,662.00 |
| **335** | **Бусад авлага** | 5,786,794.51 | 16,061,662.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 2,959,794.51 | 13,234,662.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,827,000.00 | 2,827,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 332,929,787.10 | 701,603,020.20 |
| **351** | **Түүхий эд материал** | 286,457,117.80 | 606,626,482.90 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 286,457,117.80 | 606,365,782.90 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 260,700.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 37,433,669.30 | 61,024,037.30 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,893,400.00 | 2,768,850.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 18,234,790.00 | 38,368,066.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,025,100.00 | 6,038,100.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,626,382.30 | 10.30 |
| 35450 | Барилгын засварын материал | 9,062,397.00 | 304,425.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 591,600.00 | 13,544,586.00 |
| 35600 | Мал амьтад | 9,039,000.00 | 33,952,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **618,189,619.54** | **742,539,167.70** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 618,189,619.54 | 742,539,167.70 |
| **392** | **Биет хөрөнгө** | 618,148,369.54 | 566,414,167.70 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 495,330,029.00 | 405,424,340.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -98,070,642.37 | -4,988,806.60 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 303,588,829.67 | 303,588,829.67 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -139,769,191.17 | -183,887,952.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 68,384,428.74 | 67,523,628.74 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -34,167,588.11 | -41,985,501.72 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 31,639,070.85 | 33,699,870.85 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,906,567.03 | -14,550,241.12 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,040,000.00 | 3,040,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -920,000.04 | -1,450,000.08 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 41,250.00 | 176,125,000.00 |
| 39301 | Програм хангамж | 980,000.00 | 5,180,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -938,750.00 | -980,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 171,925,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **956,906,201.15** | **1,460,203,849.90** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **2,853,630.76** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 2,853,630.76 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 2,853,630.76 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 787,968.76 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 2,065,662.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 1,975,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 90,662.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **956,906,201.15** | **1,457,350,219.14** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 956,906,201.15 | 1,457,350,219.14 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 276,984,074.85 | 448,909,074.85 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 276,984,074.85 | 448,909,074.85 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 651,088,726.30 | 838,985,896.32 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 651,088,726.30 | 651,088,726.30 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 187,897,170.02 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 28,833,400.00 | 169,455,247.97 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **956,906,201.15** | **1,460,203,849.90** |

## 3.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **461,168,878.90** | **1,955,153,844.97** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **284,713,241.90** | **858,171,723.70** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 282,580,241.90 | 858,171,723.70 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 282,580,241.90 | 858,171,723.70 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,262,300.30 | 3,810,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 3,074,258.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 277,243,683.60 | 854,361,723.70 |
| **122** | **Тусламжийн орлого** | 2,133,000.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 2,133,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **176,455,637.00** | **1,096,982,121.27** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 158,607,300.00 | 323,670,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 158,607,300.00 | 323,670,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,651,850.00 | 253,231,950.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,651,850.00 | 253,231,950.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 517,503,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 517,503,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 5,196,487.00 | 2,575,771.27 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 5,196,487.00 | 2,086,454.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 489,317.27 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **460,957,505.89** | **1,582,686,556.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **460,957,505.89** | **1,582,686,556.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 454,954,018.89 | 1,572,109,032.11 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 102,413,698.00 | 214,768,647.54 |
| 210101 | Үндсэн цалин | 102,413,698.00 | 214,768,647.54 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,460,614.00 | 26,202,078.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,373,867.00 | 17,433,788.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 818,579.00 | 2,358,323.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,023,223.00 | 1,731,138.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 204,085.00 | 425,348.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,040,860.00 | 4,253,481.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,193,647.00 | 37,817,831.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,188,269.00 | 2,889,208.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 15,571,492.00 | 31,143,047.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,433,886.00 | 3,785,576.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,798,436.75 | 89,355,797.70 |
| 210401 | Бичиг хэрэг | 859,000.00 | 2,352,210.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,308,519.86 | 13,273,676.70 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,035,444.89 | 1,608,366.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 135,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 595,472.00 | 13,094,692.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 58,891,853.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 264,449,506.60 | 354,821,547.60 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 264,449,506.60 | 354,653,547.60 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 30,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 138,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,118,135.00 | 12,241,005.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 9,068,025.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,118,135.00 | 3,172,980.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 556,000.00 | 6,684,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 556,000.00 | 6,684,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,389,150.00 | 767,152,144.30 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,104,850.00 | 765,450,328.30 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,849,700.00 | 1,041,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 286,600.00 | 288,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 145,178.00 |
| 210807 | Газрын төлбөр | 27,000.00 | 26,288.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33,574,831.54 | 63,065,980.97 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,574,831.54 | 63,065,980.97 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,003,487.00 | 10,577,524.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,003,487.00 | 10,212,314.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 5,196,487.00 | 2,086,454.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 807,000.00 | 2,700,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 5,425,860.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 365,210.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 365,210.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **211,373.01** | **372,467,288.86** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 150,709,166.77 | 184,570,118.84 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 150,709,166.77 | 184,570,118.84 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -150,709,166.77 | -184,570,118.84 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-150,497,793.76** | **187,897,170.02** |

## 3.3 МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН** | **406,792,195.30** | **1,100,302,804.00** |

| | | | |
|---|---|---|---|
| | **ДҮН (1)** | | |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,336,558.30** | **3,810,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,336,558.30 | 3,810,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 5,336,558.30 | 3,810,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,262,300.30 | 3,810,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 3,074,258.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **401,455,637.00** | **1,096,492,804.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 158,607,300.00 | 323,670,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 158,607,300.00 | 323,670,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,651,850.00 | 253,231,950.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,651,850.00 | 253,231,950.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 225,000,000.00 | 517,503,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 225,000,000.00 | 517,503,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 5,196,487.00 | 2,086,454.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 5,196,487.00 | 2,086,454.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **386,173,524.30** | **1,099,102,804.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **386,173,524.30** | **1,099,102,804.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **374,103,888.30** | **1,087,588,663.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 103,178,325.00 | 212,193,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 99,565,825.00 | 204,484,100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,612,500.00 | 7,709,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,352,000.00 | 25,463,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,352,000.00 | 18,397,850.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 2,122,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 1,697,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 424,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 2,821,450.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,872,679.00 | 38,009,831.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,188,269.00 | 3,081,208.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,571,492.00 | 31,143,047.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,112,918.00 | 3,785,576.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,677,534.00 | 15,597,267.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 541,900.00 | 2,219,760.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,159,489.00 | 9,449,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 818,324.00 | 1,590,361.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 45,000.00 | 135,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,112,821.00 | 2,202,646.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 867,500.00 | 3,692,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 867,500.00 | 2,609,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 1,083,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,122,500.30 | 7,201,380.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 446,000.00 | 967,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,676,500.30 | 6,234,280.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,535,000.00 | 7,468,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,535,000.00 | 7,468,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 228,498,350.00 | 777,961,385.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 226,082,050.00 | 775,585,969.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,000,000.00 | 1,499,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 290,300.00 | 450,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 149,678.00 |
| 210807 | Газрын төлбөр | 27,000.00 | 26,288.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,069,636.00** | **11,514,141.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,069,636.00 | 11,148,931.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 5,196,487.00 | 2,086,454.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 912,500.00 | 3,636,617.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,960,649.00 | 5,425,860.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 365,210.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 365,210.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **20,618,671.00** | **1,200,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **1,200,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **1,200,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 1,200,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 1,200,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-1,200,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 20,618,671.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 20,618,671.00 | 00.00 |

## 3.4 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **276,984,074.85** | **28,833,400.00** | **651,088,726.30** | 956,906,201.15 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **276,984,074.85** | **28,833,400.00** | **651,088,726.30** | 956,906,201.15 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 140,621,847.97 | 00.00 | 140,621,847.97 |
| Тайлант үеийн үр дүн | 171,925,000.00 | 00.00 | 187,897,170.02 | 359,822,170.02 |
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **448,909,074.85** | **169,455,247.97** | **838,985,896.32** | 1,457,350,219.14 |

## 3.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 310,530,800.00 | 297,690,226.00 | 327,170,900.00 | 327,116,171.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 310,530,800.00 | 297,690,226.00 | 327,170,900.00 | 327,116,171.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 294,434,700.00 | 285,765,078.00 | 318,095,000.00 | 318,053,694.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 204,680,000.00 | 204,676,706.00 | 212,193,900.00 | 212,193,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 196,146,200.00 | 197,766,097.00 | 174,845,700.00 | 204,484,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 00.00 | 26,020,200.00 | 00.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,533,800.00 | 6,910,609.00 | 8,448,000.00 | 7,709,800.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 | 2,880,000.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,458,400.00 | 22,458,400.00 | 25,463,300.00 | 25,463,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,458,400.00 | 22,458,400.00 | 25,463,300.00 | 18,397,850.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 00.00 | 2,122,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 00.00 | 1,697,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 00.00 | 424,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 00.00 | 2,821,450.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41,796,500.00 | 36,821,330.00 | 38,015,100.00 | 38,009,831.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,175,200.00 | 1,630,909.00 | 2,635,700.00 | 3,081,208.00 |
| 210302 | Түлш, халаалт | 37,661,300.00 | 32,206,919.00 | 31,144,000.00 | 31,143,047.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 960,000.00 | 2,983,502.00 | 4,235,400.00 | 3,785,576.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,729,800.00 | 10,303,076.00 | 15,597,800.00 | 15,597,267.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 968,100.00 | 829,800.00 | 2,352,300.00 | 2,219,760.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,277,700.00 | 8,060,000.00 | 10,307,500.00 | 9,449,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, | 1,244,000.00 | 1,093,676.00 | 1,560,000.00 | 1,590,361.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 60,000.00 | 135,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 240,000.00 | 319,600.00 | 1,318,000.00 | 2,202,646.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,867,800.00 | 2,723,250.00 | 3,692,700.00 | 3,692,700.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,587,800.00 | 2,443,250.00 | 2,800,000.00 | 2,609,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 280,000.00 | 280,000.00 | 892,700.00 | 1,083,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 408,000.00 | 375,500.00 | 8,401,400.00 | 8,401,380.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 80,000.00 | 81,000.00 | 446,000.00 | 2,167,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 328,000.00 | 294,500.00 | 7,955,400.00 | 6,234,280.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,552,000.00 | 4,025,000.00 | 7,502,600.00 | 7,468,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,552,000.00 | 4,025,000.00 | 7,502,600.00 | 7,468,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,572,200.00 | 4,018,316.00 | 7,228,200.00 | 7,226,416.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,250,000.00 | 1,250,000.00 | 4,851,200.00 | 4,851,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 | 250,000.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,747,300.00 | 2,443,816.00 | 1,500,000.00 | 1,499,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 262,000.00 | 208,800.00 | 450,000.00 | 450,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 50,000.00 | 150,000.00 | 149,678.00 |
| 210807 | Газрын төлбөр | 262,900.00 | 65,700.00 | 27,000.00 | 26,288.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 370000.00 | 363500.00 | 0.00 | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 370,000.00 | 363,500.00 | 00.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16096100.00 | 11925148.00 | 9075900.00 | 9062477.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,096,100.00 | 11,925,148.00 | 9,075,900.00 | 9,062,477.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,747,000.00 | 5,576,048.00 | 3,650,000.00 | 3,636,617.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 6,349,100.00 | 6,349,100.00 | 5,425,900.00 | 5,425,860.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 310,530,800.00 | 297,690,226.00 | 327,170,900.00 | 327,116,171.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 307,030,800.00 | 296,190,226.00 | 323,670,900.00 | 323,306,171.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 307,030,800.00 | 296,190,226.00 | 323,670,900.00 | 323,306,171.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН** | 3,500,000.00 | 1,500,000.00 | 3,500,000.00 | 3,810,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | | | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,500,000.00 | 1,500,000.00 | 3,500,000.00 | 3,810,000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 25 | 25 | 28 | 28 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17 | 17 | 19 | 19 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 07 | 07 | 07 | 07 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00 | 00 | 01 | 01 |